

ТАНИЛЦУУЛГА

Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай
Монгол Улс, ОХУ хоорондын гэрээг соёрхон батлах тухай
хуулийн төслийн тухай

Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын харилцааны эрх зүйн үндсийг Монгол Ардын Засгийн газар, Зөвлөлт Оросын Засгийн газрын хооронд 1921 онд байгуулсан найрсаг харилцаа тогтоох тухай гэрээгээр анх тавьж, дипломат харилцаатай болсон. Түүнээс хойш хоёр улсын хооронд харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх зорилгоор улс төрийн яриа хэлэлцээг эрчимжүүлж, стратегийн түншлэл тогтоож, дээд, өндөр дээд хэмжээнд айлчлал хийж ирсэн болно.

Монгол Улсын Ерөнхийлөгч П.Очирбат 1993 оны 1 дүгээр сард ОХУ-д албан ёсны айлчлал хийх үеэр хоёр улсын хооронд "Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ" байгуулснаар өнөөгийн харилцааны эрх зүйн үндэс бий болж, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагаа шинэ түвшинд гарч ирсэн. Түүнээс хойш ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевийн 2009 оны 8 дугаар сард Монгол Улсад хийсэн төрийн айлчлалын үеэр Монгол Улс, ОХУ хоорондын стратегийн түншлэл эрчимтэй өрнөж, хөгжлийн шинэ шатанд гарч буйг хоёр тал санал нэгтэй тэмдэглэж, "Стратегийн түншлэлийг хөгжүүлэх тухай тунхаглал"-д гарын үсэг зурсан билээ. Үүгээр Монгол Улс стратегийн түншлэлийн харилцааг анх ОХУ-тай тогтоосон бөгөөд энэ нь манай улсын бие даасан гадаад бодлого, хоёр талын харилцаандаа өгч буй ач холбогдлын илэрхийлэл болсон юм.

Монгол Улс ОХУ-тай хөгжиж буй харилцааны өнөөгийн түвшин болон Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлалын дагуу хоёр хөрштэй тэнцвэртэй харилцаа тогтоох үүднээс¹ ОХУ-тай "иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа" тогтоох зорилго тавьсан. Улмаар 2019 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путины албан ёсны айлчлалын үеэр "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ"-нд Монгол Улсын Ерөнхийлөгч Х.Баттулга, ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин нар гарын үсэг зурсан.

Уг гэрээ нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, аюулгүй байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хилийн халдашгүй дархан байдал, хүний эрхийг дээдэлсэн олон улсын гэрээ мөн. Гэрээний дагуу талууд иж бүрэн стратегийн түншлэл болон бүх талын харилцан ашигтай хамтын ажиллагааны хүрээнд хамтран ажиллана гэж заасан.

Гэрээнд улс төр, батлан хамгаалах, аюулгүй байдал, эдийн засаг, худалдаа, санхүү, хөрөнгө оруулалт, дэд бүтэц, тээвэр, харилцаа холбоо, эрчим хүч,

¹ Монгол Улс БНХАУ-тай "Иж бүрэн стратегийн түншлэл", АНУ, Япон, БНЭУ-тай "Стратегийн түншлэл", БНСУ, ХБНГУ, БНТуркУ-тай "Иж бүрэн түншлэл", Канад, Австрали, Казахстантай "Өргөн хүрээтэй түншлэл"-ийн харилцаа тогтоогоод байна.

мэдээллийн технологи, хүмүүнлэгийн харилцаа, соёл, урлаг, боловсрол, шинжлэх ухаан, техник, экологи, эрүүл мэнд, эрүүл ахуй, эпидемиологи болон харилцан сонирхсон бусад салбарт эрх тэгш, харилцан ашигтай хамтын ажиллагааг тогтвортой, урт хугацааны үндсэн дээр хөгжүүлэхээр тусгасан. Гэрээ нь 21 зүйлтэй бөгөөд тэдгээр нь дээр дурдсан салбараас гадна терроризм болон үндэстэн дамнасан бусад гэмт хэрэгтэй тэмцэх, эрх зүйн туслалцаа, НҮБ болон олон улсын бусад байгууллагын, түүнчлэн бүс нутгийн хүрээнд хамтран ажиллах, дамжин өнгөрөх тээвэр, далайд гарах эрх зэрэг чиглэлээр харилцаа, хамтын ажиллагааг дэмжихээр заасан.

Гэрээг байгуулахдаа хоёр тал соёрхон батлахаар тохиролцсон тул Олон улсын гэрээний тухай хуулийн дагуу соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулж, хуулийн үзэл баримтлалыг батлуулаад байна.

Хууль батлагдсанаар хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг улс төр, эдийн засаг, худалдаа, бизнес, дэд бүтэц, хүмүүнлэгийн харилцаа зэрэг бүхий л чиглэлээр өргөжүүлэн хөгжүүлж, иргэд хоорондын хэлхээ холбоог сайжруулах нөхцөл бүрдэнэ. Жишээлбэл, хоёр улс бие биедээ нээлттэй эдийн засгийн бодлого явуулж, хоёр талын худалдааг хурдацтай хөгжүүлж, бизнесийн болон бусад аж ахуйн үйл ажиллагаанд таатай нөхцөл бүрдүүлнэ.

ОХУ-тай иж бүрэн стратегийн түншлэл тогтоож байгаатай холбогдуулан Найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын 1993 оны гэрээний үйлчлэл дуусгавар болно. "Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, Оросын Холбооны Улс хоорондын гэрээ"-г хэрэгжүүлэх зорилгоор хамтын ажиллагааны тодорхой чиглэлээр бусад гэрээ байгуулна. Уг гэрээ нь хоёр улсын олон болон хоёр талт гэрээгээр хүлээсэн үүргийг хөндөхгүй.

Хууль батлагдсаны дараа хоёр тал соёрхон баталсан тухай батламж жуух бичиг солилцсон өдрөөс уг гэрээ хүчин төгөлдөр болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР